

Цацрагийн түвшний 2023 оны 07 сарын төлөв

Завхан аймгийн Ус цаг уур, орчны шинжилгээний төвийн Улиастай сумын Улиастай-01, Баянтэс сумын Баян-уул өртөөдөд **RDS-110** багажаар тус тус цацрагийн түвшний хэмжилтийг өдөр бүр 08 болон 14 цагуудад тогтмол хэмжилт хийж байна.

07 дугаар сарын хэмжилтийн дүнгээс харахад: Цацрагийн түвшний хамгийн их утга 0.13 микрозиверт/цаг, бага утга нь 0.09 микрозиверт/цаг байна.

Улиастай, Баянтэс сумдын 07 сарын агаар болон газрын гадарга дах цацрагийн түвшний тунгийн чадлын өдрийн дундаж утгийг графикаар харуулав.




График 1. Улиастай сумын агаар болон газрын гадарга дах цацрагийн түвшний тунгийн чадлын өдрийн дундаж утга




График 2. Баянтэс сумын агаар болон газрын гадарга дах цацрагийн түвшний тунгийн чадлын өдрийн дундаж утга

*Улиастай өртөөний агаар болон газрын гадарга дах цацрагийн түвшний тунгийн чадлын өдрийн дундаж утгийг өмнөх онтой харьцуулснаар дараах графикаар харуулав.




График3. Улиастай сумын агаар болон газрын гадарга дах 1 дүгээр 10 хоногийн түвшний тунгийнчадлын өдрийн дундаж өмнөх онтой харьцуулсан үзүүлэлт




График4. Улиастай сумын агаар болон газрын гадарга дах 2 дугаар 10 хоногийн түвшний тунгийнчадлын өдрийн дундаж өмнөх онтой харьцуулсан үзүүлэлт




График5. Улиастай сумын агаар болон газрын гадарга дах 3 дугаар 10 хоногийн түвшний тунгийнчадлын өдрийн дундаж өмнөх онтой харьцуулсан үзүүлэлт

Хэмжилтийн дүнгээс харахад 2022 онд агаар дах цацрагийн түвшний дунджийн хамгийн их утга нь 0.15микрозиверт/цаг, хамгийн бага утга нь 0.10 микрозиверт/цаг байсан бол 2023 онд дунджийн хамгийн их утга нь 0.12микрозиверт/цаг, хамгийн бага утга нь 0.09 микрозиверт/цаг байна. Мөн 2022 онд газрын гадарга дах цацрагийн түвшний дунджийн хамгийн их утга нь 0.13 микрозиверт/цаг, хамгийн бага нь 0.10 микрозиверт/цаг байсан бол 2023 онд дунджийн хамгийн их утга нь 0.12 микрозиверт/цаг, хамгийн бага утга нь 0.09 микрозиверт/цаг байна.

*Баянтэс сумын Баян-Уул өртөөний агаар болон газрын гадарга дах цацрагийн түвшний тунгийн чадлын өдрийн дундаж утгыг өмнөх онтой харьцуулснаар дараах графикуудаар харуулав.




График6. Баянтэс сумын агаар болон газрын гадарга дах 1 дүгээр 10 хоногийн түвшний тунгийнчадлын өдрийн дундаж өмнөх онтой харьцуулсан үзүүлэлт




График7. Баянтэс сумын агаар болон газрын гадарга дах 2 дугаар 10 хоногийн түвшний тунгийнчадлын өдрийн дундаж өмнөх онтой харьцуулсан үзүүлэлт




График8. Баянтэс сумын агаар болон газрын гадарга дах 3 дугаар 10 хоногийн түвшний тунгийнчадлын өдрийн дундаж өмнөх онтой харьцуулсан үзүүлэлт

Хэмжилтийн дүнгээс авч үзвэл 2022 онд агаар дах цацрагийн түвшний дунджийн хамгийн их утга нь 0.14 микрозиверт/цаг, хамгийн бага утга нь 0.10 микрозиверт/цаг байсан бол 2023 онд дунджийн хамгийн их утга нь 0.12 микрозиверт/цаг, хамгийн бага утга нь 0.10 микрозиверт/цаг байна. Мөн хэмжилтийн дүнгээс харвал 2022 онд газрын гадарга дах цацрагийн түвшний дунджийн хамгийн их утга нь 0.12 микрозиверт/цаг, хамгийн бага нь 0.10 микрозиверт/цаг байсан бол 2023 онд дунджийн хамгийн их утга нь 0.12 микрозиверт/цаг, хамгийн бага утга нь 0.10 микрозиверт/цаг байна.

Дэлгэрэнгүй мэдээллийг <https://www.eic.mn/radiation/> мэдээллийн сангаас харах боломжтой.